



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 1100

Мандалговь


Г “Чанс” ХХК-тай гэрээ байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Мандалговь хотын төв гудамжийг дахин хөгжүүлэх төслийн зураг, төсөв”, “Мандалговь хотын худалдааны гудамжийг дахин хөгжүүлэх төслийн зураг, төсөв” боловсруулах ажилд ирүүлсэн үнийн саналаар “Чанс” ХХК-тай тус бүр 19,855,000 (арван есөн сая найман зуун тавин таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу “Мандалговь хотын төв гудамжийг дахин хөгжүүлэх төслийн зураг, төсөв”, “Мандалговь хотын худалдааны гудамжийг дахин хөгжүүлэх төслийн зураг, төсөв” боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Чанс” ХХК-ний гүйцэтгэх захирал (Г.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Г.ЭНХТАЙВАН

486210330

